


МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2022 оны II улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia Oyu Tolgoi OTMongolia OTMongolia

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Аюулгүй ажиллагаа нь бидний нэн тэргүүний зорилт. Аюултай гэж үзсэн ямар ч ажлыг ажилтан бүр шууд **зогсоох** эрхтэй.



2022 оны хоёрдугаар
улирлын байдлаар

14,581,429
Хүн/цаг



Гүйцэтгэл
0.21



Ноцтой эрсдэлийн удирдлага

103,081
Магадлагаа

2022 оны хоёрдугаар улирлын байдлаар гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.21 ногдож байгаа нь Рио Тинто группийн хэмжээнд аюулгүй ажиллагааг сайн хангадаг уурхайн нэг болж байна.

Амь нас хамгаалах зорилготой "Ноцтой эрсдэлийн удирдлага" хөтөлбөрийн хүрээнд 103,081 магадлагаа хийлээ.

МОНГОЛ АЖИЛТНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Үүрэг 90%


96.7%



Нийт ажиллах хүчний 96.7 хувийг монгол иргэн бүрдүүлж байна. Үүнээс 33.7 хувь нь гүний уурхайн төслийн ажилтнууд юм.


УСНЫ ХЭРЭГЛЭЭ

(Нэг тонн хүдэр боловсруулахад зарцуулсан усны хэмжээ, шоо метр, сараар)



УС ДАХИН АШИГЛАЛТ

(хувь, сараар)



БОЛОВСРОЛ СУРГАЛТ

(Нийт хүн/цаг)



Нийт 30,505 хүн/
цагийн сургалтад
ажилтнуудаа
хамруулан ур
чадварыг нь
өсгөсөөр байна.

**БОЛОВСРОЛЫН
ХӨТӨЛБӨР**
(Тэтгэлэг, бусад хөтөлбөрүүд)
2011 оноос хойш
3,727 оюутан,

**ЗАЛУУСЫН
ХӨГЖЛИЙН
ХӨТӨЛБӨР**
2013 оноос хойш ахлах
ангийн 1,330 сурагч,

**"ГОВИЙН ОЮУ" САН,
МАЛЧИН ӨРХИЙН
ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ**
2010 оноос хойш
Өмнөговийн 432 оюутан
тус тус хамрагджээ.

ҮНДЭСНИЙ ХУДАЛДАН АВАЛТ

(2010 - 2022/II улирал, сая ам.доллар)



2022 онд үйл ажиллагааны худалдан авалтын баг 722 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 490 нь үндэсний компани байв. Эдгээр үндэсний компанид худалдан авалтынхаа 75 хувийг зарцуулав. 2010 оноос хойш үндэсний худалдан авалтад 4.53 тэрбум ам.доллар зарцуулсан.

УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2013 - 2022/II улирал)




МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2022 оны II улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia Oyu Tolgoi OTMongolia OTMongolia

ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2010 - 2022/II улирал, сая ам.доллар)



2010 оноос хойш өсөн нэмэгдсэн дүнгээр

3.74

ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫГ татвар хураамж, бусад төлбөрт төлжээ.

2010 оноос хойш татвар, хураамж, үндэсний компаниудад төлсөн НӨАТ зэрэг бусад төлбөрт 3.74 тэрбум ам.долларыг төлсөн. 2022 оны эхний хоёр улиралд татвар, хураамж бусад төлбөрт 163 сая ам.доллар төлжээ.


* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

** Энэ дүнд олон улсын арбитраг хэлэлцэж буй 356 сая ам.долларын төлбөр багтсан болно.

ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ

(2010 - 2022/II улирал, тэрбум ам.доллар)

2010 оноос хойш үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалинд 14.2 тэрбум ам.доллар зарцууллаа.



ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД


(сая ам.доллар)



2022 оны эхний хоёр улиралд тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд 3.1 сая ам.долларын санхүүжилт олгожээ.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ


(2010 - 2022/II улирал, сая ам.доллар)



2022 онд Өмнөговь аймагт бүртгэлтэй 94 ханган нийлүүлэгчээс 130 сая ам.долларын бараа, үйлчилгээ авлаа. 2010 оноос хойш Өмнөговь аймгаас нийт 1,017 тэрбум ам.долларын бараа, үйлчилгээ авчээ.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ


(мян.тонн)



2022 оны хоёрдугаар улиралд 30,555 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэв. 2022 онд 110,000 – 150,000 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлт хангалттай байна.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ


(мян.унц)



2022 оны хоёрдугаар улиралд 47,631 унц баяжмал дахь алт үйлдвэрлэв. "Туркойз Хилл Ресурс" компани 2022 оны баяжмал дахь алт үйлдвэрлэх төлөвлөгөөг 135,000-165,000 байсныг 150,000-170,000 унц болгон шинэчилсэн.

ГҮНИЙ УУРХАЙН ХӨНДЛӨН НЭВТРЭЛТ

(метр, сараар)



2022 оны хоёрдугаар улиралд гүний уурхайд хөндлөн малталтын гүйцэтгэл 4,135.1 метрийн ахицтай байв.